

Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
2021 оны 09 сарын 27-ний өдрийн хурлын  
23-р тогтоолын 1 дүгээр хавсралт



## ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН ЗАЛГАМЖ ХАЛААНЫ БОДЛОГЫН ЖУРАМ

### НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1 Энэхүү Гүйцэтгэх удирдлагын залгамж халааны бодлогын журам /цаашид "Журам" гэх/-ын зорилго нь "Говь" ХК (цаашид "Компани" гэх)-ийн гүйцэтгэх удирдлагын залгамж халааг бэлтгэх, залгамжлах замаар Компанийн удирдлагын тогтвортой, үр бүтээлтэй ажиллах нөхцөлийг хангах үйл ажиллагааг зохицуулахад оршино.
- 1.2 Энэхүү Журамд залгамж халааны төлөвлөлт, тэдгээрийг хэрэгжүүлэх этгээдийн үүрэг хариуцлага, сул орон тоонд залгамжлан ажиллах хүнийг олж томилох, сонгон шалгаруулах үйл ажиллагааг явуулах журмуудыг тодорхойлно.
- 1.3 Компанийн зорилго, зорилт, үнэлэмжийг олон нийтийг төлөөлсөн, мэргэшсэн, чадварлаг удирдлагатай байх бодлогыг Компанийн зүгээс баримтална.

### ХОЁР. ЗАЛГАМЖ ХАЛААНЫ БОДЛОГО

- 2.1 Гүйцэтгэх удирдлага ажил үүргээ түр хугацаагаар гүйцэтгэх боломжгүй (өвчтэй, чөлөөтэй, гадаад дотоод томилолттой г.м) тохиолдолд түүний бүрэн эрхийг тухайн хугацаагаар Тэргүүн дэд захирал хэрэгжүүлнэ.
- 2.2 Гүйцэтгэх удирдлага ажлаас халагдсан буюу ажил үүргээ цаашид гүйцэтгэх боломжгүй нөхцөл байдал бий болсон бол Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс нэн яаралтай дор дурдсан ажиллагааг хийнэ.

Хийгдэх ажил	Хариуцах эзэн	Хугацаа
Компанийн ажилтнуудад гүйцэтгэх удирдлага чөлөөлөгдөж байгаа тухай мэдээлэх	Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга	Гүйцэтгэх удирдлага ажлаас чөлөөлөгдсөнөөс хойш 24 цагийн дотор
Гүйцэтгэх удирдлага өөрчлөгдсөнтэй холбоотой Компанийн харилцагч төрийн болон банк санхүүгийн байгууллагуудад мэдээлэл хүргэх	Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга	Гүйцэтгэх удирдлага ажлаас чөлөөлөгдсөнөөс хойш 7 хоногийн дотор
Гүйцэтгэх удирдлагад ажиллах боломжит хүмүүсийн анкет, туршлагыг судлах, шаардлагатай бол хүний нөөцийн зөвлөх үйлчилгээний компанид хандах	Төлөөлөн Удирдах Зөвлөл	Гүйцэтгэх удирдлага ажлаас чөлөөлөгдсөнөөс хойш 7 хоногийн дотор
Гүйцэтгэх удирдлагыг томилохоос өмнө Компанийн бизнесийн үйл ажиллагаанд нэн яаралтай шийдвэрлэх шаардлагатай асуудлуудыг олж тогтоож, шийдвэрлэх	Төлөөлөн Удирдах Зөвлөл	Гүйцэтгэх удирдлага ажлаас чөлөөлөгдмөгц



<p>Гүйцэтгэх удирдлагыг сонгон шалгаруулах үйл ажиллагааг явуулах хугацааг тогтоох,</p> <p>Компанийн зүгээс Гүйцэтгэх удирдлагыг аль болох олон нэр дэвшигчээс сонгон шалгаруулалт хийж томилно.</p>	<p>Төлөөлөн Удирдах Зөвлөл</p>	<p>Гүйцэтгэх удирдлага ажлаас чөлөөлөгдсөнөөс хойш 7 хоногийн дотор</p>
--	--------------------------------	---


2.3 Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга эзгүй буюу дээр дурдсан үйл ажиллагааг гүйцэтгэх боломжгүй болсон бол Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдээс тухайн ажлыг гүйцэтгүүлэхээр томилж болно.

### ГУРАВ. ХАРИЛЦАА ХОЛБОО

- 3.1 Гүйцэтгэх удирдлага ажлаас чөлөөлөгдөх үед Компанийн харилцагч, түнш байгууллагууд, түүнчлэн ажилтнуудын Компанид итгэх итгэлийг эерэгээр хадгалах нь чухал. Үүнийг хэрэгжүүлэхэд харилцаа холбоон дээр дараах зүйлсийг анхаарвал зохино.
- 3.1.1 Гүйцэтгэх удирдлага ажлаас чөлөөлөгдөж байгаа тухай бүхий л харилцаа (мэйл, мэдэгдэл, вэбсайт, албан бичиг, уулзалт г.м) ил тод, нээлттэй байх;
  - 3.1.2 Гүйцэтгэх удирдлага юуны учир ажлаас чөлөөлөгдөж буй тухай боломжит хэмжээгээр мэдээлэл өгөх;
  - 3.1.3 Компанийн бусад ажилтнууд болон удирдлагын багийг Компанийн тогтвортой үйл ажиллагаанд итгэх эерэг хандлагад төвлөрүүлэх;
  - 3.1.4 Дараагийн гүйцэтгэх удирдлагыг сонгон шалгаруулах үйл ажиллагаанд анхаарах зүйлсийн талаар ажилтнуудаас Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга болон бусад эрх бүхий этгээдэд илэрхийлсэн санал хүсэлтэд нээлттэй хандах;
  - 3.1.5 Шинэ гүйцэтгэх удирдлага томилогдмогц ажилтнуудад албан ёсоор танилцуулах арга хэмжээг зохион байгуулах.

### ДӨРӨВ. ХЯНАЛТ, САЙЖРУУЛАЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

- 4.1 Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга энэхүү Журмын хэрэгжилтийг хангаж Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүд хяналт тавина.
- 4.2 Төлөөлөн Удирдах Зөвлөл, түүний дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны саналд үндэслэн Журамд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.



**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ**